



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/614

Улаанбаатар хот

«Багануур дүүргийн онцгой байдлын хэлтсийн
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/614 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 13,623,100 (арван гурван сая зургаан зуун хорин гурван мянга нэг зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Г.Батжаргал)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Г.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Н.Мөнхбаатар)-т тус тус даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000729

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны 08 дугаар сарын 19 -ны өдрийн 08/19 -р тушаалын хавсралт

Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

/төг/

д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс	Хьюндай старекс 77-44 УБМ	11,273,100.00	11,273,100.00	-
2		Бага оврын трактор	2,350,000.00	2,350,000.00	-
Дүн			13,623,100.00	13,623,100.00	-